

цалин хөлс олгох тухай эрх зүйн зохицуулалтыг байгууллагын дотоод журам бусад эрх зүйн актуудад тусгах нь цаашид чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Төрийн алба хаагчийн төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулинд тусгаснаар үр дүнгийн гэрээний дагуу үнэлж дүгнэх нь хангалтгүй юм. Иймд байгууллага дотоод журмаараа ажлыг сар, улирлаар үнэлэн, дүгнэж идэвхжүүлэх асуудлыг нарийвчлан тусгах шаардлагатай гэж үзлээ.

*Ц.Мөнхбат- ХСИС, Хууль сахиулах удирдлагын
Академийн 8022 дамжааны суралцагч,
цагдаагийн дэд хурандаа*

ШИНЖЭЭ ЧИЙН ХАРАА Т БУС БАЙДЛЫГ ХУУЛЬ ЧИЛСАН НЬ

Хураангуй: Шүүхийн шинжилгээний байгууллагын болон шинжээчийн хараат бус байдал. Хараат бус байдалд нөлөөлөх хүчин зүйлс. Шинжээчийн нийгмийн болон хууль, эрх зүйн баталгаа. Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийгдэж байгаа шинжилгээ, Шинжээчийн тухай авч үзлээ.

Түлхүүр үгс: Шинжээч, шинжилгээний тухай, шинжээчийн хараат бус байдлын тухай, хараат бус байдалд нөлөөлөх хүчин зүйлс, нийгмийн болон хууль, эрх зүйн баталгаа, эцэг, эх тогтоох шинжилгээ кодлох тухай.

Монгол Улсын 1992 оны Үндсэн Хуульд Монгол Улсын иргэн үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэхийг заасан.

Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй¹ гэж заасан. Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөгч нар гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийн эрх, эрх чөлөөг хязгаарладаг.

Монгол Улсад төрийн өндөр албан тушаалтан, улс төрийн болон бизнесийн бүлэглэл, хөрөнгө чинээтэй хүмүүсийн нөлөөлөл улам бүр хүчирхэгжиж байгаа талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр өдөр тутам ярьж. бичих боллоо.

¹ Монгол Улсын Үндсэн Хууль, Хоёрдугаар бүлэг, 16 дугаар зүйл, Улаанбаатар хот, 1992 он.

Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд ял завших, гэм буруугүй хүн хохирохгүй байх. хүний эрх, эрх чөлөөг хангах гол хүчин зүйл нь шинжээчийн дүгнэлт юм. Хүний эрх, эрх чөлөө хангагдах гол хүчин зүйл бол шинжээч хараат бусаар дүгнэлт гаргах явдал юм.

Шинжээчийн хараат бус байдал гэдэг нь аливаа дарамт, нөлөөллөөс ангид байдлаар зөвхөн баримт нотолгоо. шинжлэх ухааны арга, аргачлал, хуульд тулгуурлан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шинжээчийн дүгнэлт гаргах хэмээн ерөнхий байдлаар тодорхойлж болохоор байна.

Шинжээчийн дүгнэлт гаргах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хязгаарласнаар байгууллагын хараат бус байдал хангагдана. Байгууллагын хараат бус байдал гэдэгт байгууллагын бүтэц, хуулиар тогтоосон үүрэг, чиглэлийн дагуу бие дааж үйл ажиллагаа явуулахыг хэлнэ.

Шинжээчийн хараат бус байдлыг дараахь байдлаар авч үзвэл зохино.

- > Шинжээчийн хараат бус байдал (гадаад, дотоод хүчин зүйлс)
- > Шүүхийн шинжилгээний байгууллагын хараат бус байдал

Шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлст хөндлөнгийн аливаа этгээдийн дарамт шахалт, хууль бус санал, хүсэлт, гүтгэх, шинжээчийн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүнийг шууд болон шууд бус арга хэлбэрээр айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэх, хэл амаар доромжлох, үйлчилгээ үзүүлж тал засах, эсхүл үйлчлэхгүй байх, хараах, айлган сүрдүүлэх, найз нөхөд, танил тал, ах, дүү, хамаатан, садангийн хүнээр дамжуулан нөлөөлөхийг оролдох, авлига, хээл хахууль, шан харамж өгөхийг завдах, эдлэх үндсэн эрхийг хязгаарлах зэргээр нөлөөлөх байдал гарч болзошгүй юм.

Шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйлст гэр бүл, найз нөхөд, хамт ажиллагсадаас хууль бус санал, хүсэлт тавих, шан харамж өгөх, шууд удирдах дарга үүрэг болгох гэх мэт нөлөөлөл юм.

Байгууллагын хараат бус байдалд нөлөөлөх хүчин зүйлст яам, агентлаг, улс төрийн намаас нөлөөлж хууль бус шийдвэр гаргуулах, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэд, нийгмийн цахим сүлжээ (facebook, youtube, twiter) дарамт шахалт үзүүлэх, сүрдүүлэх, гүтгэх, заналхийлэх, худал мэдээлэл тараах зэрэг нөлөөлөл юм. Энэ асуудлыг судлан тогтоож, нийгмийн энэхүү сөрөг, эрүүл бус үзэгдлийн эсрэг хараат бус байдлыг хамгаалах нь зайлшгүй хийх ажил болоод байна.

Шинжээчийн хараат бус байдлаар ажиллахад нийгмийн баталгаа, хууль эрх зүйн баталгаа хангагдсан байх ёстой.

Нийгмийн баталгаа:

Шинжээчийн цалин хөлс, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөл муу байгаагаас авлигад өртөх, хээл хахууль, шан харамж авахгүй гэх баталгаа байхгүй байна.

Анхан шатны шүүхийн шүүгч 2,7 сая төгрөгийн цалинтай бол Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч 3,3 сая төгрөгийн цалинтай аж.¹ Хэрэг бүртгэгч, мөрдөгч, шинжээчийн цалин 830-860 мянган төгрөгийн орчим байгаа нь анхан шатны шүүгчээс 3 дахин бага цалин авч байна.

Шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөгч нар шинжээчийн дүгнэлтийг үндэслэн хэрэг маргааныг шийдвэрлэдэг. Гэмт хэргийг илрүүлэхэд үнэн бодит нотлох баримт чухал байдаг. Эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэг монгол ардын зүйр үг бий. Уг нь нотлох баримт бүрдүүлж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөгч, шинжээч нарын цалин, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөлийг сайжруулснаар хараат бусаар ажиллах нөхцөл бүрдэж, хүний эрх, эрх чөлөө хангагдах ёстой болов уу. Аймгийн пгүүхийн шинжилгээний алба, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын харьяа дүүргийн криминалистикийн шинжилгээний тасгууд нь цагдаагийн байгууллагын байранд байрлаж, үйл ажиллагаагаа явуулж байгаа нь цагдаагийн байгууллагаас хараат байх орчин нэгэнт бүрдсэн байна.

Хууль, эрх зүйн баталгаа:

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан.

Тус төвд Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Шинжилгээний хүрээлэнг нэгтгэсэн бөгөөд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн бүтэц, зохион байгуулалтыг баталсан.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь шинжилгээ томилж буй этгээд, болон улс төрийн нам, яам, агентлаг, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, ашиг сонирхолын зөрчилтэй этгээдээс үйл ажиллагаа чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах нь чухал байсан тул Монгол Улсын Их хурлын 2009 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Шүүхийн шинжилгээний тухай” хууль батлагдсан нь

¹ <http://time.mn/ri/fi3>

үйл ажиллагааны зарчим. чиг үүргийг тодорхойлж. байгууллагын тогтолцоог баталгаажуулсан анхны бие даасан хуультай болсон.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 42 дугаар зүйлд ...''хуулийг дээдлэн биелүүлж, гагцхүү шинжлэх ухааны бодит үнэнд захирагдан үнэнчээр ажиллаж, төрийн тусгай албан хаагчийн сахилга, ёс зүйг чанд сахихаа батлан тангараглая" гэсэн нь шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан тангарагтаа үнэнч байж, сахин биелүүлэх нь үүрэг юм.

Тус хуулийн 4 дүгээр зүйлд шүүхийн шинжилгээ хийхэд баримтлах зарчмыг зааж өгсөн. Үүнд:

4.1.1. хууль дээдлэх;

4.1.2. хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

4.1.3. хараат бус байх;

4.1.4. нууцыг хадгалах;

4.1.5. шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх.

Хоёрдугаар бүлэг: Шүүхийн шинжилгээ хийх нийтлэг журам;

12 дугаар зүйл шинжилгээ хийх журам;

13 дугаар зүйл шинжээчийн эрх;

14.1.1. шинжилгээг тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд тал бүрээс нь бүрэн, бодитой хийх;

14.1.2. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээ хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах;

14.1.7. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах;

15.1.1. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдийн хүсэлт, шийдвэрээр шинжилгээ хийх;

15.1.4. шинжилгээ хийхийн тулд өөрийн санаачилгаар баримт материал цуглуулах;

15.1.5. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдэд шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэхийг хориглоно;

16.1.2. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн төрөл садан байвал;

16.1.3. шинжээч нь албан тушаалын болон бусад талаар хэргийн оролцогчийн эрхшээлд байгаа бол;

16.1.4. хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, түүнчлэн тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал шинжилгээ хийж дүгнэлт гаргахаас татгалзана;

Гуравдугаар бүлэг “Зарим төрлийн шинжилгээний онцлог”;

Дөрөвдүгээр бүлэг “Хүний биед шинжилгээ хийх”

43.4. шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.

43.5. шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно¹ гэж заажээ.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дүгээр зүйлийн

1.4. шинжээчид тавьсан асуулт нь түүний тусгай мэдлэгийн хүрэнээс хэтэрсэн, эсхүл тусгай мэдлэгт хамаарахгүй, эсхүл шинжилгээ хийх баримт сэлтэд холбогдох хүн, байгууллагатай ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;

1.6. аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргах эрхтэй.

2. шинжээч нь шүүх, прокурор, мөрдөгчийн тавьсан асуултын дагуу тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргана.

10.11 дүгээр зүйлийн 1.2. эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

1.3. шинжээч нь албан тушаалын болон бусад талаар оролцогчийн эрхшээлд байгаа бол;

1.4. оролцогчтой хувийн харилцаатай бол;

1.5. шинжилгээ хийлгэх тухай тогтоолд тавьсан асуулт шинжээчийн тусгай мэдлэгийн хүрэнээс хэтэрсэн, эсхүл тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол шинжээч шинжилгээ хийх, дүгнэлт гаргахаас татгалзана² гэж заасан. Дээрх хуулийн заалтууд нь шинжээч хараат бусаар ажиллах эрх зүй орчин бүрдсэн байна. Гэвч шинжээчийн хараат бус байдалд халдсан заалт Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуульд тусгагдсан байна.

Тухайлбал, Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн шинжээчийн эрх, үүрэг дэх хэсгийн 3-т дүгнэлт гаргасан шинжээч нь мэдүүлэг авахаар шүүх, прокуророос дуудсан цагт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй бол гүүнийг энэ хуульд заасны дагуу шүүхийн

¹ Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль, Улаанбаатар хот, 2009 он

² Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улаанбаатар хот, 2017 он

шийдвэрээр албадан ирүүлнэ' гэж заасан нь шинжээчийн эрх, үүрэг, зүй бусаар халдсан, хараат бус дүгнэлт гаргах боломжийг хязгаарласан заалт юм.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн шинжээчийн хараат бус байдлыг хангах зорилгоор Хууль зүйн сайдын 2013 оны 6/01 дүгээр тушаалаар Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтсийг шинээр байгуулсан.

Тус хэлтэс нь шинжилгээний объектыг хүлээн авах, шинжээчид хуваарилах, хүлээлгэн өгөх, шинжилгээ хийх хугацаанд бүртгэлээр хяналт тавих, шинжилгээний объектын бүрэн бүтэн байдалд хяналт тавих, шинжилгээ томилсон этгээд, байгууллагатай харилцах, хамтран ажиллах, шинжээчийн хараат бус байдлыг хангах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг. Шинжилгээ томилсон эрх бүхий этгээд, хохирогч, өмгөөлөгч, сэжигтэн, ашиг сонирхол бүхий этгээдтэй шинжээч шууд харьцдаг байсныг таслан зогсоож, тус хэлтэс шинжээчийн хараат бус байдлыг хангаж зохион байгуулан ажиллаж байна.

Тухайлбал, эцэг, эх тогтоох шинжилгээний дээжийг тус хэлтсийн мэргэжилтэн эцэг, эх, хүүхдээс биологийн дээж (цус, шүлс, үс) авч, код (ТОО, үсэг) бичиж хаягжуулан шинжээчид хуваарилна. Кодлогдсон шинжилгээний дээжийг хүлээн авсан шинжээч эцэг, эх, хүүхдийн овог нэрийг мэдэх боломжгүй бөгөөд ямар шинжээчид хуваарилагдсаныг бусад шинжээч болон ашиг сонирхол бүхий этгээдүүд мэдэх боломжгүй юм. Эцэг, эх тогтоох шинжилгээг кодлосон нь шинжээчийн хараат бус байдлаар ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль 9 дүгээр зүйл. Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх, Монгол Улсын Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.4 дүгээр зүйл. Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх гэсэн заалтын дагуу барилгын инженерийн шинжилгээ, байгаль орчин, эд хөрөнгийн үнэлгээ, эмийн шинжилгээ, химийн зарим төрлийн шинжилгээнүүд шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийгддэг. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийдэггүй шинжилгээнүүд үнэн бодитой шинжээчийн дүгнэлт гардаггүй гэдэг нь дараах болсон үйл явдлаас харагдаж байна.

Тухайлбал, Монголын “TV25 суваг” телевизийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн “25 цаг мэдээллийн хөтөлбөр”-өөр сурвалжлагч Б.Энхзулын бэлтгэн гаргасан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Үндэсний лавлагаа лаборатори нь Монгол Улсад импортоор орж ирж байгаа эм, эмийн бодисонд шинжилгээ хийж Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэнд, спортын яаманд шинжээчийн дүгнэлтээ хүргүүлдэг байна.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Улаанбаатар хот, 2017 он

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэнд, спортын яам, Үндэсний лавлагаа лабораторийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэж Монгол Улсад импортоор орж ирэх эм, эмийн бодисын зөвшөөрөл олгодог байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Үндэсний лавлагаа лабораторийн шинжээч нар “Ксезолин” хамрын дусаалга нь химийн болон биологийн ҮФО-ийн төслийн шаардлага хангахгүй байна гэж гаргасан шинжээчийн дүгнэлтийг лабораторийн менежер Д.Өлзийдулам, дэд захирал Т.Барчинлэгсэм нар өөрчилж, шаардлага хангаж байна гэсэн шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

Мөн “Womens Prenatal” витамин нь бактериологийн шинжилгээгээр витаминС нь 54-92,7 мг байх ёстой атал 0,0042мг байх тул шаардлага хангахгүй гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан. Энэ шинжээчийн дүгнэлтийг лабораторийн менежер Д.Өлзийдулам, дэд захирал Т.Барчинлэгсэм нар өөрчилж, шаардлага хангаж байна гэсэн шинжээчийн дүгнэлт гаргасан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирал Б.Амар дээрх болсон үйл явдлыг хууль хяналтын байгууллага шалгаж байна гэсэн ярилцлага өгсөн байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан бүр үүрэг, хариуцлагаа ухамсарлаж, чин шударгаар ажиллах, ёс зүйн шаардлага тулгарч байна. Ард түмэн үнэн бодитой шинжээчийн дүгнэлт, хараат бус шинжээчийг хүлээж байна. Мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадвараа улам бүр дээшлүүлж, сэтгэлгээний төлөвшил, туршлага өндөр түвшинд хүрсэн байх, ах, дүү, танил тал, найз нөхөд, нутаг нугын үзэл гаргах, хээл хахуульд автах, албан тушаалаа урвуулан ашиглах, авлигын аливаа хор хөнөөлт, бусармаг ажиллагааг хязгаарладаг байх ёстой.

ДҮГНЭЛТ

Сүүлийн үед шүүхийн шинжилгээний байгууллагад үл итгэх байдал иргэдийн дунд бий болж, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр нэвтрүүлэг гарах. нийгмийн цахим сүлжээгээр гүтгэлгийн шинжтэй мэдээлэл түгэх болсон нь анхаарал татаж байна. Шүүхийн шинжилгээний байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн бие даасан, хараат бус байдлаар явуулах, шинжээч хараат бус байдлаар ажиллахыг өнөөгийн нийгэм шаардаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага болон шинжээчийн хараат бус байдал, гадаад, дотоод хүчин зүйлсийг судлаж, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг арилгах, бууруулах шаардлагатай байна.

Шинжээчийн нийгмийн баталгаа болсон цалин хөлс, орон байр, хангамж, урамшуулал, ажиллах орчин, нөхцөл муу байгаагаас авлигад өртөх, хээл хахууль, авахгүй гэх баталгаа байхгүй байна.

Өндөр хөгжилтэй гадаад улсын хууль, эрх зүй, тэргүүн туршлагыг судлаж, Монгол Улсын Шүүхийн шинжилгээний тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Шинжээч нар нь өндөр ёс зүйтэй, шударга, хариуцлагатай байх, шинжлэн магадлахуйн мэдлэгээ байнга дээшлүүлэх, сургалтанд тогтмол хамрагдах зэрэг ажлуудыг тогтмол, тасралтгүй явуулах шаардлагатай байна.

САНАЛ

1. Монгол Улсын анхан шатны шүүхийн шүүгч 2,7 сая төгрөгийн цалин авдаг. Шинжээчийн цалин, урамшуулал, хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлснээр ажил мэргэжилдээ хандах хандлага өөрчлөгдөж, хараат бусаар хариуцлагатай, шударга ажиллах сэтгэл зүтгэл бий болгох,

2. Аймгийн шүүхийн шинжилгээний алба, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын харьяа дүүргийн Криминалистикийн шинжилгээний тасгуудын хараат бус байдлыг хангахын тулд шаардлага хангасан өөрийн гэсэн байртай болгох,

3. Шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөхийг завдсан л бол тодорхой арга хэмжээ авч, гомдол, хүсэлтээ шууд захирах дарга болон эрх бүхий байгууллагад гаргадаг, мэдэгддэг байх,

4. Шинжээчийн хараат бус байдлын нөлөөлөх нөлөөллийн хэлбэрүүдийг тодорхойлж, хүлээлгэх хариуцлагыг хуульчлах, эрүүгийн болон зөрчлийн тухай хуулиудад нэмэлт оруулах,

5. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа Үндэсний лавлагаа лабораторийн менежер Д.Өлзийдулам, дэд захирал Т.Барчинлэгсэм нар нь шинжээчийн дүгнэлтийг бусдад ашигтай байдлаар өөрчилсөн. Иймд барилгын инженерийн шинжилгээ, байгаль орчин, эд хөрөнгийн үнэлгээ, эм, эмийн бодисын шинжилгээ, химийн зарим төрлийн шинжилгээнүүдийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хийдэг болох,

6. Анагаах ухааны их сургууль төгссөн эмч, давтан сургалтанд хамрагдаж эмчлэх эрхийн зөвшөөрөл авдаг. Хуульч, эрх зүйч мэргэжилтэй хүн шалгалт өгч өмгөөлөх эрх авдаг. Шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй тусгай мэргэжил эзэмшсэн этгээдэд нь Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шинжилгээ хийх эрх олгодог болох. Тусгай мэргэжил